ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 29 өдөр Дугаар А/90 Арвайхээр сум

Сургалтын болон унааны зардалд
хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6, Засаг даргын 2020-2024 оны үйл ажилалгааны хөтөлбөрийн 1.4.4.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Монголын сурагчдын холбооноос зохион явуулдаг "Өсвөрийн 333 сургагч багш бэлтгэх" үндэсний хөтөлбөрт Арвайхээр сумаас хамрагдах сурагчдын сургалтын төлбөр, унааны зардалд 2,305,200 (хоёр сая гурван зуун таван мянга хоёр зуу) төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2.Дээрх зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг нягтлан бодогч (Н.Нацагням)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.ГАНБАТ

D:\2024\Alban bichig\Zahiramj- 2024.docx

Сумын Засаг даргын 2024 оны
..... дугаар сарын ..19.–ны өдрийн
А/90 дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын төрөл	Нэг бүрийн үнэ	Хүний тоо	Дүн
1	2	3	4	5
1.	Сургалтын төлбөр	295,000	6	1,770,000
2.	Ирэх, очих унааны зардал	89,200	6	535,200
Нийт дүн				**2,305,200**

АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР